АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өндөр-Улаан сумын ЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** АРА-2026/061/НА-СТА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэбулган хот 2026 он | Дарга, тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа<br>Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860 Цахим хаяг:Nerguibaatard@audit.gov.mn<br>Цахим актив аудит ХХК: Аудитор: Д.Эрдэнэцэцэг<br>Утас:99019943 Цахим хаяг: tsakhimactive@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 112

танай ____________-ны №____________-т

ӨНДӨР-УЛААН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА О.МӨНХТУЯА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Ерөнхий гэрээгээр жагсаалтад орсон эм эмийн хэрэгслийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, төсвийг зохистой удирдаж, дотоод хяналт хэрэгжүүлээгүй 4,917.6 мянган төгрөг,
- Эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуурыг тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүдээс худалдан аваагүй, ААЭМГ/20250102001 дугаартай гэрээний хэрэгжилт хангалтгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй,
- Шөнийн нэмэгдлийг ЭМС-ын 2020 оны А/69 тоот тушаалын дагуу олгоогүй 58,465.0 мянган төгрөг,
- НББ-ийн ОУ-ын стандартад нийцүүлэн эм, боох материалын дансанд бүртгэлтэй тусгай зориулалтын материалыг зөв ангилан бүртгээгүй,
- Орон нутгаас олгож байгаа тогтмол зардлын санхүүжилтээс байр ашиглалтын зардалтай холбоогүй машины сэлбэг худалдан авч зориулалт бус зарцуулсан 2,090.0 мянган төгрөг,
- Үндсэн хөрөнгө данснаас хасахдаа Орон нутгийн өмчийн газрын албан бичгээр хассан боловч данснаас хасах хөрөнгийг нэр төрлөөр жагсааж хавсралтаар

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **334,638,994.41** | **360,196,737.24** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 2,986,191.44 | 447,913.48 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 2,986,191.44 | 447,913.48 |
| **3121** | **Төгрөг** | 2,986,191.44 | 447,913.48 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 2,986,191.44 | 447,913.48 |
| **33** | **АВЛАГА** | 251,439,513.98 | 276,297,089.30 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 251,439,513.98 | 220,414,927.30 |
| **335** | **Бусад авлага** | - | 55,882,162.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 55,882,162.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 80,213,288.99 | 83,451,734.46 |
| **351** | **Түүхий эд материал** | 10,463,285.49 | 6,445,746.72 |
| 35130 | Эм боох материал | 10,463,285.49 | 6,445,746.72 |
| **354** | **Хангамжийн материал** | 69,750,003.50 | 77,005,987.74 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 527,750.00 | 578,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 67,318,453.50 | 74,914,987.74 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 375,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,903,800.00 | 1,137,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **958,624,793.31** | **872,112,934.44** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 958,624,793.31 | 872,112,934.44 |
| **392** | **Биет хөрөнгө** | 944,354,793.31 | 858,082,934.44 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 660,929,862.88 | 660,929,862.88 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (155,903,500.35) | (167,721,817.59) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 334,803,260.00 | 251,111,260.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (119,706,741.12) | (72,969,593.20) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 301,415,303.00 | 325,914,403.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (86,558,449.63) | (145,819,473.21) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 13,191,451.60 | 13,191,451.60 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (3,816,393.07) | (6,553,159.04) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 14,270,000.00 | 14,030,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,200,000.00 | 1,200,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (940,000.00) | (1,180,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 14,010,000.00 | 14,010,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,293,263,787.72** | **1,232,309,671.68** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **10,772,500.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 10,772,500.00 |
| **413** | **Өглөг** | - | 10,772,500.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 10,772,500.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 10,772,500.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,293,263,787.72** | **1,221,537,171.68** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,293,263,787.72 | 1,221,537,171.68 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 377,631,204.13 | 377,631,204.13 |
| 51101 | Өмч: - төрийн | 377,631,204.13 | 377,631,204.13 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 590,622,603.61 | 518,895,987.57 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 590,622,603.61 | 590,622,603.61 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (71,726,616.04) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 325,009,979.98 | 325,009,979.98 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,293,263,787.72** | **1,232,309,671.68** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,379,888,486.79** | **1,540,223,514.55** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **28,971,676.58** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 28,971,676.58 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 28,971,676.58 |
| 120009 | Бусад орлого | | 280,000.00 |
| 1200017 | Үнэ төлбөргүй орлого -Үндсэн хөрөнгө | | 3,499,100.00 |
| 1200018 | Үнэ төлбөргүй орлого -Бараа материал | | 25,192,576.58 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,379,888,486.79** | **1,511,251,837.97** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 43,270,000.00 | 49,107,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 43,270,000.00 | 49,107,500.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | - | 73,498,171.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 73,498,171.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 1,336,618,486.79 | 1,388,646,166.97 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,336,618,486.79 | 1,388,646,166.97 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,267,302,821.39** | **1,611,950,130.92** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,267,302,821.39** | **1,611,950,130.92** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,260,664,077.93 | 1,470,943,646.92 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 846,113,452.50 | 948,334,811.70 |
| 210101 | Үндсэн цалин | 487,015,978.25 | 518,180,650.66 |
| 210102 | Нэмэгдэл | 289,823,763.25 | 327,357,749.06 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,566,000.00 | 24,937,000.00 |
| 210104 | Урамшуулал | 61,515,681.00 | 76,832,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 3,192,030.00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 97,260,570.96 | 115,560,053.44 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 66,768,394.15 | 79,589,953.91 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,687,453.12 | 9,364,087.10 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,429,600.00 | 5,701,621.68 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,749,693.85 | 4,431,323.50 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,625,429.84 | 17,500,478.90 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 33,923,581.97 | 28,160,640.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,950,514.54 | 11,365,640.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 25,984,767.43 | 15,745,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 988,300.00 | 1,050,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 55,811,566.23 | 56,212,626.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,522,150.00 | 5,904,066.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 32,742,673.00 | 34,740,260.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,179,579.23 | 5,796,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,283,600.00 | 1,049,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,083,564.00 | 8,722,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 134,786,980.54 | 161,606,710.91 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 99,168,140.54 | 122,510,063.21 |
| 210502 | Хоол, хүнс | 28,003,840.00 | 33,086,147.70 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 7,615,000.00 | 6,010,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,182,000.00 | 18,702,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 900,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,182,000.00 | 17,802,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,574,000.00 | 3,020,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,574,000.00 | 3,020,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,310,212.00 | 13,268,726.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,357,000.00 | 12,857,550.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 194,100.00 | 72,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 50,000.00 | 18,200.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 209,112.00 | 320,176.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 80,701,713.73 | 126,077,578.87 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,958,000.00 | 15,066,620.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 68,743,713.73 | 111,010,958.87 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 6,638,743.46 | 141,006,484.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 130,434,624.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 18,820,624.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 41,214,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 70,400,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 6,638,743.46 | 10,571,860.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,638,743.46 | 10,571,860.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **112,585,665.40** | **(71,726,616.37)** |

| | | | |
|---|---|---|---|
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 38,094,420.00 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 38,094,420.00 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (38,094,420.00) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **74,491,245.40** | **(71,726,616.37)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,153,811,888.81** | **1,542,556,425.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **325,217,685.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 325,217,685.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | - | 324,937,685.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 73,498,171.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | | 251,439,514.00 |
| 120009 | Бусад орлого | | 280,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,153,811,888.81** | **1,217,338,740.00** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 43,270,000.00 | 49,107,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 43,270,000.00 | 49,107,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 1,110,541,888.81 | 1,168,231,240.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,110,541,888.81 | 1,168,231,240.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,206,896,236.44** | **1,534,867,202.96** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,206,896,236.44** | **1,534,867,202.96** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,200,257,492.98** | **1,393,860,718.96** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 868,053,793.11 | 948,334,811.72 |
| 210101 | Үндсэн цалин | 487,015,978.25 | 494,479,871.66 |
| 210102 | Нэмэгдэл | 309,602,212.86 | 352,085,940.06 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,566,000.00 | 24,937,000.00 |
| 210104 | Урамшуулал | 63,677,572.00 | 76,832,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 3,192,030.00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 103,043,768.90 | 115,560,053.44 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 71,737,151.69 | 79,689,954.17 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,320,278.68 | 9,424,718.28 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,429,600.00 | 5,289,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,931,308.69 | 4,517,199.26 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,625,429.84 | 16,638,381.73 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,631,256.54 | 28,535,640.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,950,514.54 | 11,365,640.00 |
| 210302 | Түлш, халаалт | 18,692,442.00 | 16,120,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 988,300.00 | 1,050,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 53,855,752.23 | 57,871,760.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,540,900.00 | 5,554,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 32,742,673.00 | 35,565,160.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,179,579.23 | 5,796,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,292,600.00 | 1,184,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,100,000.00 | 9,771,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 112,045,010.20 | 131,795,745.80 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 76,089,310.20 | 98,792,945.80 |
| 210502 | Хоол, хүнс | 27,205,900.00 | 26,992,300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 8,749,800.00 | 6,010,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 15,906,700.00 | 81,930,662.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,061,100.00 | 4,100,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 12,845,600.00 | - |
| 210604 | Урсгал засвар | - | 77,830,662.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,574,000.00 | 3,020,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,574,000.00 | 3,020,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,440,212.00 | 11,883,726.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,487,000.00 | 11,205,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 194,100.00 | 109,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 50,000.00 | 23,200.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 209,112.00 | 546,126.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 12,707,000.00 | 14,928,320.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,707,000.00 | 14,928,320.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,638,743.46** | **141,006,484.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 130,434,624.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 18,820,624.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 41,214,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 70,400,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 6,638,743.46 | 10,571,860.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,638,743.46 | 10,571,860.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(53,084,347.63)** | **7,689,222.04** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **10,227,500.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **10,227,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 10,227,500.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 10,227,500.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(10,227,500.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (53,084,347.63) | (2,538,277.96) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 2,986,191.44 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 2,986,191.44 | 447,913.48 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 377,631,204.13 | 325,009,979.98 | 590,622,603.61 | 1,293,263,787.72 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **377,631,204.13** | **325,009,979.98** | **590,622,603.61** | 1,293,263,787.72 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **377,631,204.13** | **325,009,979.98** | **590,622,603.61** | 1,293,263,787.72 |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **377,631,204.13** | **325,009,979.98** | **590,622,603.61** | 1,293,263,787.72 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **377,631,204.13** | **325,009,979.98** | **590,622,603.61** | 1,293,263,787.72 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (71,726,616.04) | (71,726,616.04) |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **377,631,204.13** | **325,009,979.98** | **518,895,987.57** | 1,221,537,171.68 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,892,266,900.00 | 1,534,242,842.94 | 358,024,057.06 | 18.9 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,892,266,900.00 | 1,534,242,842.94 | 358,024,057.06 | 18.9 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,720,890,700.00 | 1,403,808,218.94 | 317,082,481.06 | 18.4 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,059,436,100.00 | 948,334,811.37 | 111,101,288.63 | 10.5 |
| 210101 | Үндсэн цалин | 566,965,400.00 | 494,479,871.31 | 72,485,528.69 | 12.8 |
| 210102 | Нэмэгдэл | 290,164,700.00 | 352,085,940.06 | (61,921,240.06) | -21.3 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 78,115,600.00 | 24,937,000.00 | 53,178,600.00 | 68.1 |
| 210104 | Урамшуулал | 124,190,400.00 | 76,832,000.00 | 47,358,400.00 | 38.1 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 132,066,100.00 | 115,560,053.44 | 16,506,046.56 | 12.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 88,873,800.00 | 79,689,954.17 | 9,183,845.83 | 10.3 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,798,100.00 | 9,424,718.28 | 1,373,381.72 | 12.7 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,399,000.00 | 5,289,800.00 | 109,200.00 | 2.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,399,000.00 | 4,517,199.26 | 881,800.74 | 16.3 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,596,200.00 | 16,638,381.73 | 4,957,818.27 | 23.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 39,107,500.00 | 28,535,640.00 | 10,571,860.00 | 27.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 21,937,500.00 | 11,365,640.00 | 10,571,860.00 | 48.2 |
| 210302 | Түлш, халаалт | 16,120,000.00 | 16,120,000.00 | - | 0.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,050,000.00 | 1,050,000.00 | - | 0.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 82,037,400.00 | 57,871,760.00 | 24,165,640.00 | 29.5 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,041,400.00 | 5,554,100.00 | 487,300.00 | 8.1 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 57,912,800.00 | 35,565,160.00 | 22,347,640.00 | 38.6 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,304,500.00 | 5,796,300.00 | 508,200.00 | 8.1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,292,600.00 | 1,184,700.00 | 107,900.00 | 8.3 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,486,100.00 | 9,771,500.00 | 714,600.00 | 6.8 |
| **2105** | **Нормативт зардал** | 204,265,500.00 | 131,795,745.80 | 72,469,754.20 | 35.5 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 167,294,200.00 | 98,792,945.80 | 68,501,254.20 | 40.9 |
| 210502 | Хоол, хүнс | 28,221,500.00 | 26,992,300.00 | 1,229,200.00 | 4.4 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 8,749,800.00 | 6,010,500.00 | 2,739,300.00 | 31.3 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 153,655,200.00 | 92,158,162.00 | 61,497,038.00 | 40.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 25,500,000.00 | 14,327,500.00 | 11,172,500.00 | 43.8 |
| 210604 | Урсгал засвар | 128,155,200.00 | 77,830,662.00 | 50,324,538.00 | 39.3 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 14,723,200.00 | 3,020,000.00 | 11,703,200.00 | 79.5 |
| 210702 | Дотоод албан томилолт | 14,723,200.00 | 3,020,000.00 | 11,703,200.00 | 79.5 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 14,175,200.00 | 11,603,726.33 | 2,571,473.67 | 18.1 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,205,200.00 | 8,925,200.33 | 2,279,999.67 | 20.3 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,000,000.00 | 2,000,000.00 | - | 0.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 200,000.00 | 109,200.00 | 90,800.00 | 45.4 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 50,000.00 | 23,200.00 | 26,800.00 | 53.6 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 720,000.00 | 546,126.00 | 173,874.00 | 24.1 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 21,424,500.00 | 14,928,320.00 | 6,496,180.00 | 30.3 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,424,500.00 | 14,928,320.00 | 6,496,180.00 | 30.3 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 171,376,200.00 | 130,434,624.00 | 40,941,576.00 | 23.9 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 171,376,200.00 | 130,434,624.00 | 40,941,576.00 | 23.9 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 19,994,000.00 | 18,820,624.00 | 1,173,376.00 | 5.9 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 53,382,000.00 | 41,214,000.00 | 12,168,000.00 | 22.8 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 98,000,200.00 | 70,400,000.00 | 27,600,200.00 | 28.2 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,853,266,800.00 | 1,531,704,564.98 | 321,562,235.02 | 17.4 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 49,107,500.00 | 38,535,640.00 | 10,571,860.00 | 21.5 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 49,107,500.00 | 38,535,640.00 | 10,571,860.00 | 21.5 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,804,159,300.00 | 1,168,231,240.00 | 635,928,060.00 | 35.2 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | - | 324,937,684.98 | (324,937,684.98) | 0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 73,498,171.00 | (73,498,171.00) | 0 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | | 251,439,513.98 | (251,439,513.98) | 0 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **2,986,191.44** | (2,986,191.44) | 0 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **447,913.48** | (447,913.48) | 0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 30 | 30 | - | 0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 20 | 20 | - | 0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 9 | 6 | 3.00 | 0 |
| 620004 | Гэрээт ажилтан | - | 3 | (3.00) | 0 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 473,091.6 мянган төгрөгийн алдаа[1] илэрч, санхүүгийн тайланд 406,904.6 мянган төгрөгийн алдаанд залруулга хийлгэлээ.

Залруулгын алдаа:

- ✓ *Урьдчилж гарсан зардлыг өглөгөөр тусгасан 46,551.8 мянган төгрөгийн өглөг данснаас бууруулсан,*
- ✓ *Урьдчилж гарсан зардлыг авлагаар бүртгээгүй 55,882.2 мянган төгрөгийг авлага дансанд бүртгэсэн,*
- ✓ *Хөрөнгийн бүртгэлд байгаа хөрөнгөд элэгдэл тооцоогүй 20,646.5 мянган төгрөгийг хөрөнгийн элэгдэл нэмж тооцсон,*
- ✓ *Хийгдээгүй ажлыг үндсэн хөрөнгөнд хий бүртгэсэн 98,434.0 мянган төгрөгийг барилга байгууламж данснаас хассан,*
- ✓ *Мөнгөн хөрөнгийн тайланд орлого бүрэн тусгаагүй 98,120.9 мянган төгрөгийг мөнгөн хөрөнгийн тайланд тусгасан,*
- ✓ *Төсвийн гүйцэтгэлийн тайланг цэвэр гүйцэтгэлээр тайлагнаагүй 87,269.1 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тус тус 2026.01.31-ны 11 тоот албан бичгээр залруулсан*

Аудитаар залруулагдаагүй 66,186.9 мянган төгрөгийн зөрчил[2] илэрсэнд 1 төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь 66,186.9 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 20,296.8 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

### *5.1.1 Бараа материалын зарцуулалттай холбоотой*

*Илрүүлэлт: Хоол хүнсийг худалдан авахдаа Засаг даргын А/50 тоот захирамжаар шалгарсан тендерийн үнээс өндөр үнээр хүнсний эрүүл ахуйн гарал үүслийн бичиггүй хүнс худалдан авсан 714,3 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.15.2-д "энэ хуулийн 27.2, 27.5, 27.7.5-д заасан гэрчилгээгүй бүтээгдэхүүн худалдан авах тээвэрлэх, зөөвөрлөхгүй байх"*

*Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоож төсөвт төвлөрүүлэх*

### *5.1.2 Байр ашиглалтын зардалтай холбоотой*

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*Илрүүлэлт: Орон нутгаас олгож байгаа тогтмол зардлын санхүүжилтээс байр ашиглалтын зардалтай холбоогүй урсгал зардал болох машины сэлбэг худалдан авч зориулалт бус зарцуулсан 2,090.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.*

*Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо*

**5.2 Албан шаардлага**

***5.2.1 Тендэрийн худалдан авалттай холбоотой***

*Илрүүлэлт: Эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуурыг тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүдээс худалдан аваагүй, ААЭМГ/20250102001 дугаартай гэрээний хэрэгжилт хангалтгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй 4,917.6 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.*

*Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31-р зүйлийн 31.2-т “Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.*

*Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох гэрээний үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүллээ*

***5.2.2 НББ, тайлагналтай холбоотой***

*Илрүүлэлт: Үндсэн хөрөнгө данснаас хасахдаа төрийн өмчийн албан тоотоор хассан боловч албан тоот нь нэр төрлөөр жагсааж хавсралт батлаагүй, хөрөнгийн үнэлгээ хэрхэн хийсэн нь тодорхой бус, акталсан хөрөнгийг устгах тушаал шийдвэргүй, устгалтын акт үйлдээгүй, хөрөнгө ангилан бүртгээгүй зөрчил тус тус илэрлээ.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.*

*Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож дахин гаргахгүй байх хөрөнгөд тавих хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүллээ*

***5.2.3 Цалингийн зардалтай холбоотой***

*Илрүүлэлт: Шөнийн нэмэгдлийг ЭМС-ын 2020 оны А/69 тоот тушаал шийдэрийн дагуу олгоогүй 58,465.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2 -д "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д “Нягтлан*

*бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.*

*Шийдвэрлэсэн нь: Илүү цагийг бодож олгохдоо тушаал шийдвэрийн дагуу олгох*

**5.3 Зөвлөмж**

***5.3.1 Эм, боох материалын худалдан авах ажиллагаатай холбоотой***

*Илрүүлэлт: Ерөнхий гэрээгээр жагсаалтад орсон эм, эмийн хэрэгслийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, төсвийг зохистой удирдаж, дотоод хяналт хэрэгжүүлээгүй 4,917.6 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.*

*Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.*

*Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж дотоод хяналтыг сайжруулах*

***5.3.2 НББ, тайлагналтай холбоотой***

*Илрүүлэлт:НББ-ийн ОУ-ын стандартад нийцүүлэн эм, боох материалын дансанд бүртгэлтэй тусгай зориулалтын материалыг зөв ангилан бүртгээгүй зөрчил илэрлээ.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2 -д "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.*

*Шийдвэрлэсэн нь: Бараа материалын тооллогыг чанартай хэрэгжүүлэх, НББ-ийн ОУ-ын стандартын дагуу бараа материалыг ангилан бүртгэх*

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу шийвдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Архангай аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдааны утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: Залруулсан | | Үүнээс: Залруулаагүй | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Өндөр-Улаан ЭМТ | Урьдчилж гарсан зардлыг өглөгөөр тусгасан | 1 | 46,551.8 | | | 1 | 46,551.8 | 1 | 46,551.8 | | |
| | Урьдчилж гарсан зардлыг авлагаар бүртгээгүй | 1 | 55,882.2 | 1 | 55,882.2 | | | 1 | 55,882.2 | | |
| | Хөрөнгийн бүртгэлд байгаа хөрөнгөд элэгдэл тооцоогүй | 1 | 20,646.5 | 1 | 20,646.5 | | | 1 | 20,646.5 | | |
| | Хийгдээгүй ажлыг хөрөнгөнд хий бүртгэсэн | 1 | 98,434.0 | | | 1 | 98,434.0 | 1 | 98,434.0 | | |
| | Мөнгөн хөрөнгийн тайланд орлого бүрэн тусгаагүй | 1 | 98,120.9 | 1 | 98,120.9 | | | 1 | 98,120.9 | | |
| | Төсвийн гүйцэтгэлийн тайланг цэвэр гүйцэтгэлээр тайлагнаагүй | 1 | 87,269.1 | | | 1 | 87,269.1 | 1 | 87,269.1 | | |
| **Нийт дүн** | | **6** | **406,904.5** | 3 | 174,649.6 | 3 | 232,254.9 | **6** | **406,904.5** | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| **Аудитад хамрагдсан байгууллагын нэр** | **Алдаа, зөрчлийн товч утга** | **Нийт алдаа, зөрчлийн дүн** | | **Үүнээс: Төлбөрийн акт** | | **Үүнээс: Албан шаардлага** | | **Үүнээс: Зөвлөмж** | | **Үүнээс: Хууль, хяналтын байгууллагад** | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Өндөр-Улаан сумын ЭМТ | Эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуурыг тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүдээс худалдан аваагүй, ААЭМГ/20250102001 дугаартай гэрээний хэрэгжилт хангалтгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй | 1 | - | | | 1 | | | | | |
| | Хоол хүнсийг худалдан авахдаа сумын нэгдсэн тендер шалгаруулалтанд санал өгөөгүй, шалгарсан тендерийн үнээс өндөр үнээр хүнс худалдан авсан, нийлүүлж байгаа хүнсний эрүүл ахуй гарал үүслийн бичиг байхгүй, Засаг даргын А/50 тоот захирамжийн биелэлт хангалтгүй | 1 | 714.3 | 1 | 714.3 | | | | | | |
| | Ерөнхий гэрээгээр жагсаалтанд орсон эм эмийн хэрэгсэлийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, төсвийг зохистой удирдаж, дотоод хяналт хэрэгжүүлээгүй | 1 | 4,917.6 | | | | | 1 | 4,917.6 | | |
| | Шөнийн нэмэгдлийг ЭМС-ын 2020 оны А/69 тоот тушаал шийдэрийн дагуу олгоогүй | 1 | 58,465.0 | | | 1 | 58,465.0 | | | | |
| | НББ-ийн ОУ-ын стандартад нийцүүлэн эм, боох материалын дансанд бүртгэлтэй тусгай зориулалтын материалыг зөв ангилан бүртгээгүй | 1 | - | | | | | 1 | | | |
| | Орон нутгаас олгож байгаа тогтмол зардлын санхүүжилтээс байр ашиглалтын зардалтай холбоогүй урсгал зардал болох машины сэлбэг худалдан авч зориулалт бус зарцуулсан | 1 | 2,090.0 | 1 | 2,090.0 | | | | | | |
| | Үндсэн хөрөнгө данснаас хасахдаа төрийн өмчийн албан тоотоор хассан боловч албан тоот нь нэр төрлөөр жагсааж хавсралт батлаагүй, хөрөнгийн үнэлгээ хийгээгүй, акталсан хөрөнгийг устгах тушаал шийдвэргүй, устгалтын акт үйлдээгүй | 1 | - | | | 1 | | | | | |
| **Нийт дүн** | | **7** | **66,186.9** | **2** | **2,804.3** | **3** | **58,465.0** | **2** | **4,917.6** | | |